

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2023
 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 3/163
 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт



"НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ" ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2021, 2022, 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХЭРЭГЖИЛТ

2023 оны 06 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Д/д	№	Бодлогын зорилго, зорилт арга хэмжээ	Төсөв /сая төг/		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт	Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь	Тайлбар (Хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)	Хариуцах байгууллага
			Төсөвлөсөн	Гүйцэтгэл		Он	Түвшин	Он	Түвшин				

Зорилт 3.5. Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1			0	0	Биеийн тамирын арга зүйч	0	2023	Биеийн тамирын 9 арга зүйчтэй болсон байна.	Биеийн тамир, спортын тухай хуульд дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах санал гарган тусгуулахаар 2021оны 05 дугаар сарын 03-нд Биеийн тамир, спортын улсын хороонд, 2022 оны 08 дугаар сарын.02-нд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст, 2022 оны 11 дүгээр сарын .21-нд 3/235 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст тус тус хүргүүлсэн бол "Биеийн тамирын хамтлаг"-ийн журам шинэчлэгдэж байгаатай холбогдуулан орон тооны болон орон тооны бус арга зүйч ажиллуулах саналыг 2022 оны 04 дүгээр сарын 04-нд Биеийн тамир, спортын улсын хороонд тус тус хүргүүлсэн. 2023 онд Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дээрх санал тусгагдан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн байна Үр дүн: Анхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх нөхцөлийг сайжруулах чиглэлээр санал санаачилга гарган шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.	30%	Биеийн тамир, спортын тухай хуульд орон тооны арга зүйч ажиллуулах заалт тусгуулж батлуулснаар тус ажил хэрэгжинэ. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь манай байгууллагын чиг үүрэг биш болно.	НБТСГ
---	--	--	---	---	--------------------------	---	------	---	--	-----	--	-------

2	3.5.1	Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна.	2019	0	0	Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб	11	2023	22	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайд, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 дүгээр тушаалаар батлагдсан иргэдэд идэвхтэй хөдөлгөөн биеийн тамир, спортоор хичээллэх үйлчилгээ үзүүлж буй байгууллагад магадлан итгэмжлэлийн үнэлгээ хийх журмын дагуу 2021 онд 2 спорт клуб магадлан итгэмжлэлд хамрагдан 13, 2022 онд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 46 фитнес клуб, 4 сплиннинг төвд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлснээр Налайх дүүргийн "Налайх сплиннинг", Сонгинохайрхан дүүргийн Бумбод фитнес клубийн материалыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн. Үр дүн: Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллаж иргэдэд үзүүлэх чанартай үйлчилгээг нэмэгдүүлэхийн тулд 2 спорт клуб магадлан итгэмжлэлд хамрагдаж, 2 спорт клубыг магадлан итгэмжлэлд хамруулахаар хүсэлт хүргүүлсэн.	50%	Магадлан итгэмжлэлд сайн дурын үндсэн дээр хамрагдах хуулийн заалттай. Магадлан итгэмжлэх ажлыг Засгийн газрын тохируулагч агентлаг - Биеийн тамир, спортын улсын хороо хариуцна.	НБТСГ
				0	0	Иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт	53	2023	58	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг нийслэлийн хэмжээнд 2021 онд Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас шалтгаалан зохион байгуулж чадаагүй. 2022 онд бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 175.417 иргэнийг хамруулсан ба сорилд хамрагдсан нийт иргэдийн 80 хувь нь А,В,С үнэлгээ авсан бол 2023 оны эхний хагас жилд 115,684 иргэн хамрагдаж нийт иргэдийн 59 хувь нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй байна. Үр дүн: Тухайн хүний бие бялдрын чийрэгжилт яг одоо ямар түвшинд байгааг тусгай боловсруулсан асуумж, хэмжилтийн үндсэн дээр гаргаж дүгнэлт хийж зөвлөгөө өгч ажилласан.	90%	Намар 9-10 сард сорилыг үргэлжлүүлэн авч үнэлнэ.	НБТСГ

4			0	0	Төрөлжсөн спортын талбай	94	2023	105	Стандарт шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын талбайг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн орон сууц, гэр хорооллын дунд 3*3 сагсан бөмбөгийн 7 талбай, 2022 онд Хан-Уул дүүргийн 8-р хороонд Хөлбөмбөгийн талбай бүхий техникийн төв тус тус шинээр байгуулагдсан. Сүхбаатар дүүргийн 2-р сургууль, Хан – Уул дүүргийн 34, 52-р сургуулиудын гаднах талбайг спортын төрөлжсөн талбай болгон тохижуулсан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар 34 байршилд 3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулагдаж нийт 139 талбайтай болоод байна. Үр дүн: Спортын төрөлжсөн талбайг 44-өөр нэмэгдүүлж 139 болгосон.	90%	2023 онд 40 байршилд стандарт шаардлагад нийцсэн 3x3 сагсан бөмбөгийн талбайг тохижуулах ажлыг Нийслэлийн Хот тохижуулах газраас хийнэ.	НБТСГ
5	3.5.2	Дүүрэг, хороод болон шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир, спортын барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан байна.	Улсын төсвөөс 3,511.6	Улсын төсвөөс 1,748.0	Спортын барилга байгууламжийн хүртээмж	60	2023	62	Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэн 2021 онд Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор, Хан-Уул дүүрэгт битүү дээвэртэй өвлийн спортын ордон шинээр ашиглалтад орж, Баянгол дүүргийн 4-р сургуулийн спорт заал, Багануур дүүргийн 1 хороонд спорт заал, 20 дугаар сургуульд усан бассейн шинээр ашиглалтад оруулсан бол 2022 онд Баянгол дүүргийн 15-р хороо хороонд 650 хүний суудалтай спорт цогцолбор, 3-р хороонд 3000 хүний суудалтай "UG Arena" спорт цогцолбор тус тус ашиглалтад орсон. Налайх дүүргийн спорт цогцолбор 90 хувьтай, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85 хувьтай, Сүхбаатар дүүргийн спорт цогцолбор 40 хувьтай, Нийслэлийн Спорт цогцолбор 50 хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 40 хувьтай, Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 50 хувьтай хэрэгжиж байна. Үр дүн: Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмжийг 2 мкв-аар нэмэгдүүлж 62 мкв болсон.	90%	2023 оны сүүлийн хагаст спортын барилга байгууламжуудын барих явц үргэлжилнэ.	НБТСГ

6	3.5.3	Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна.	Нийслэлийн төсвөөс 1,500.0	Улсын төсвөөс 47.7 Нийслэлийн төсвөөс 357.1	Нийт хүн амд биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдсан иргэн	2019	725,196	2023	800,000	Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын дараа иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх зэрэгт хэрэгцээнд тулгуурлан нийслэлийн хэмжээнд (Илүүдэл жингүй-Эртэч монгол" аян, "Алхацгаая-Гүйцгээе" хөдөлгөөн, "Цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастик" "Гимнастрада" уралдаант үзлэг, "Улаанбаатар марафон" олон улсын гүйлт, нутгийн захиргааны байгууллагуудын спортын наадам, иргэдийн спортын наадам гэх мэт) арга хэмжээнүүдийг зохион байгуулж 2021 онд 635,486 иргэнийг, 2022 онд 1,170,073 иргэн, 2023 оны эхний хагас жилд 335,345 иргэн хамруулсан. Үр дүн: Иргэдийн дунд зохион байгуулагдах нийтийн биеийн тамирын арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлэн ажиллаж 2023 оны эхний хагас жилд 335,345 иргэн хамруулаад байна.	70%	2023 оны сүүлийн хагас жилд зохин байгуулахаар төлөвлөгдсөн ажлууд хүлээгдэж байна.	НБТСГ
7	3.5.4	Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна.	Улс, нийслэлийн төсвөөс 480.000,0	Улсын төсвөөс 63.1 Нийслэлийн төсвөөс 173,8	Тэмцээнд оролцсон тамирчид	2019	152,096	2023	152,200	Нийслэл дүүргийн хэмжээнд багийн спорт, үндэсний болон өвлийн спортын төрлүүдээр өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн дунд 2021 онд 30 спортын төрлөөр 131016 тамирчин, 2022 онд 23 спортын төрлөөр 180661 тамирчин, 2023 оны эхний хагас жилд 21 спортын төрлөөр зохион байгуулж 122490 тамирчин хамруулаад байна. Үр дүн: Спортын тэмцээн уралдаанд 122490 тамирчин хамруулсан	70%	2023 оны сүүлийн хагас жилд зохин байгуулахаар төлөвлөгдсөн ажлууд хүлээгдэж байна.	НБТСГ
8		Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх зорилгоор 9 Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багуудыг 2021 онд 23 төрлөөр 61 багт 90 дасгалжуулагч 2570 тамирчин 2022 онд спортын 24 төрлөөр 65 багт 101 дасгалжуулагч, 2856 тамирчдын бүрэлдэхүүнтэй, 2023 оны хагас жилийн байдлаар 25 төрлөөр 69 багт 89 дасгалжуулагч 2440 тамирчдын бүрэлдэхүүнтэй сургалт, дасгалжуулалтад хамруулж байна. Үр дүн: спортын 25 төрөлд өсвөрийн шигшээ баг сургалт, дасгалжуулалтад хамрагдаж байна.	Улс, нийслэлийн төсвөөс 555.5	Орон нутгийн төсвөөс 27,4	Өсвөрийн шигшээ багуудын спортын төрөл	2019	22	2023	24	90%	Өсвөрийн шигшээ багуудын сургалт дасгалжуулалтын үйл ажиллагаа 2023 оны сүүлийн хагас жилд үргэлжилнэ.	НБТСГ	


9	3.5.5	Нийслэл Улаанбаатар хотноо олон улсын спортын наадмыг зохион байгуулж дэлхийд сурталчлан таниулах ажлыг шат дараатай зохион байгуулсан байна.	Улс, нийслэл, бусад 11,200,0	Нийслэлийн төсөв 6,800.0	Улаанбаатар хотноо зохион байгуулж буй Олон улсын спортын наадам	2019	0	2023	"Улаанбаатар -2023" Зүүн азийн залуучуудын наадмыг зохион байгуулсан байна.	"Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадмын бүтээн байгуулалтын ажил 90 хувь (хөлбөмбөгийн ногоон талбай бүхий техникийн төв-100%, Спортын ордон /бэлтгэлийн төв/-80%)-тай үргэлжилж байгаа бол "Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг спорт, ёслолын ажиллагаа, наадмын байгууламжууд, байр, сууц, ажиллах хүч, хангамж, тээвэр, мэдээлэл технологи, хэвлэл мэдээлэл, олон улсын харилцаа, протокол, баталгаажилт, бүртгэл, аюулгүй байдал, олон нийттэй харилцах, маркетинг гэсэн 15 чиглэлд байгуулан гүйцэтгэл 76.3 хувьтай үргэлжилж байна. Үр дүн: "Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадам зохион байгуулах бэлтгэл ажлыг 83.2 хувьд хүргэсэн.	83%	2023 оны 08 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөгдсөн тул бэлтгэл ажлууд хангагдаж байна.	НБТСГ
Хэрэгжилтийн дундаж										74%			

ТАНИЛЦСАН:
НИИСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ж.ГАНБОЛД

М.ЦОГЗОЛМАА

Б.ОЮУНТУЯА

Г.БЯМБАСАЙХАН

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 3/163 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт



Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Биеийн тамир, спортын чиглэлээр туссан зорилт, шалгуур үзүүлэлтийн 2021, 2022, 2023 оны эхний хагас жилийн тайлан

2023 оны 06 дугаар сарын 13

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) өссөн дүнгээр	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний тайлбар	Хариуцах байгууллага
3. ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА										
1		3.5.1. Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна.	2021 - 2025	0	0	Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн 60 хувь нь А, В, С үнэлгээ авсан байна.	2021 онд гаргасан жишиг бүтцийн дагуу нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороодын албан хаагчдын тоо 2022 онд 175 үүнээс биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн 84, 2023 оны эхний хагас жилд 183 албан хаагчид үүнээс биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн 98 ажиллаж байна. Биеийн тамир, спортын тухай хуульд дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах саналыг 2022 онд тусгуулахаар Биеийн тамир, спортын улсын хороо, НЗДТГ-н Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэст тус тус албан тоотоор хүргүүлсэн. Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дээрх санал нь 2023 онд тусгагдан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн. Тухайн санал "Биеийн тамир, спортын тухай хууль"-д тусгагдсанаар хэрэгжинэ. Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллаж чанартай үйлчилгээг нэмэгдүүлэхийн тулд 2021 онд 2 спорт клубийг магадлан итгэмжлэлд хамруулж, 2022 онд 2 спорт клубыг магадлан итгэмжлэлд хамруулахаар хүсэлт хүргүүлсэн боловч магадлан итгэмжлэх үйл ажиллагаа 2021 оноос түр зогсож журмаа шинэчилж байгаатай холбогдуулан хойшлогдоод байна. Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулсан нийтийн биеийн тамирын арга хэмжээнд 2021 онд 635,486 иргэн, 2022 онд 1,170,073 иргэн, 2023 оны эхний хагас жилд 335,345 иргэн хамрагдсан байна. Үр дүн: Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж 2022 онд 175.417 иргэнийг хамруулж, сорилд хамрагдсан нийт иргэдийн 80 хувь нь А,В,С үнэлгээ авсан бол 2023 оны эхний хагас жилд 115,684 иргэн хамрагдаж нийт иргэдийн 59 хувь нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй байна.	60 %	зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай.	НБТСГ

2	3.5. Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	3.5.2. Дүүрэг, хороод болон шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир, спортын барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан байна.	2021 - 2025	Улсын төсвөөс 3,511.6	Улсын төсвөөс 1,748.0	Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмж 63мкв, спортын талбай 139 болсон.	<p>Стандарт шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын талбайг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн орон сууц, гэр хорооллын дунд 3*3 сагсан бөмбөгийн 7 талбай, 2022 онд Хан-Уул дүүргийн 8-р хороонд Хөлбөмбөгийн талбай бүхий техникийн төв, Сүхбаатар дүүргийн 2-р сургууль, Хан – Уул дүүргийн 34, 52-р сургуулиудын гадна талбайг тус тус шинээр тохижуулсан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар 34 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулагдаж нийт 139 талбайтай болоод байна.</p> <p>Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэн 2021 онд Хан-Уул дүүрэгт битүү дээвэртэй өвлийн спортын ордон шинээр ашиглалтад орж, Баянгол дүүргийн 4-р сургуулийн спорт заал, Багануур дүүргийн 1 хороонд спорт заал, 20 дугаар сургуульд усан бассейн шинээр ашиглалтад оруулсан бол 2022 онд Баянгол дүүргийн 15-р хороо хороонд 650 хүний суудалтай спорт цогцолбор, 3-р хороонд 3000 хүний суудалтай "UG Arena" спорт цогцолбор тус тус ашиглалтад орсон. Налайх дүүргийн спорт цогцолбор 90 хувьтай, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85 хувьтай, Сүхбаатар дүүргийн спорт цогцолбор 40 хувьтай, Нийслэлийн Спорт цогцолбор 50 хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 40 хувьтай, Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 50 хувьтай хэрэгжиж байна.</p> <p>Үр дүн: Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмжийг 2 мкв-аар нэмэгдүүлж 62 мкв болсон бол спортын төрөлжсөн талбайг 44-өөр нэмэгдүүлж 139 болгосон.</p>	10 0%	тодорхой үр дүнд хүрсэн	НБТСГ
3		3.5.3. Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	Нийслэлийн төсвөөс 1.500,0	Улсын төсвөөс 47.7 Нийслэлийн төсвөөс 357.1	Эхний хагас жилд 335,345 иргэн хамрагдсан.	<p>Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын дараа иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх эрэлт хэрэгцээнд тулгуурлан нийслэлийн хэмжээнд (Илүүдэл жингүй-Эртэч монгол" аян, "Алхацгаая-Гүйцгээе" хөдөлгөөн, "Цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастик" "Гимнастрада" уралдаант үзлэг, "Улаанбаатар марафон" олон улсын гүйлт, нутгийн захиргааны байгууллагуудын спортын наадам, иргэдийн спортын наадам гэх мэт) арга хэмжээнүүдийг зохион байгуулж 2021 онд 635,486 иргэнийг, 2022 онд 1,170,073 иргэн, 2023 оны эхний хагас жилд 335,345 иргэн хамруулсан.</p> <p>Үр дүн: Иргэдийн дунд зохион байгуулагдах нийтийн биеийн тамирын арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлэн ажиллаж 2023 оны эхний хагас жилд 335,345 иргэн хамруулаад байна.</p>	70 %	тодорхой үр дүнд хүрсэн	НБТСГ

4	3.5.4. Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна.	2021 - 2025	Улсын төсвөөс 110.0 Нийслэлийн төсвөөс 322.3	Улсын төсвөөс 63.1 Нийслэлийн төсвөөс 173,8	Спортын тэмцээн уралдаанд 122490 тамирчин хамруулсан бол спортын 25 төрлөөр өсвөрийн шигшээ баг сургалтад хамрагдаж байна.	Нийслэл дүүргийн хэмжээнд багийн спорт болон үндэсний спорт, өвлийн спортын төрлүүдээр өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн дунд 2021 онд 30 спортын төрлөөр 131016 тамирчин, 2022 онд 23 спортын төрлөөр 180661 тамирчин, 2023 оны эхний хагас жилд 21 спортын төрлөөр зохион байгуулж 122490 тамирчин хамруулаад байна. Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх зорилгоор 9 дүүргийн Засаг дарга нарын дэргэдэх өсвөрийн шигшээ багуудыг 2021 онд 23 төрлөөр 61 багт 90 дасгалжуулагч 2570 тамирчин 2022 онд спортын 24 төрлөөр 65 багт 101 дасгалжуулагч, 2856 тамирчдын бүрэлдэхүүнтэй, 2023 оны хагас жилийн байдлаар нийт 25 төрлөөр 69 багт 89 дасгалжуулагч 2440 тамирчдын бүрэлдэхүүнтэй сургалт, дасгалжуулалтад хамруулж байна. Үр дүн: Спортын тэмцээн уралдаанд 122490 тамирчин хамруулсан бол спортын 25 төрөлд өсвөрийн шигшээ баг сургалт, дасгалжуулалтад хамрагдаж байна.	85 %	тодорхой үр дүнд хүрсэн	НБТСГ
5	3.5.5. Нийслэл Улаанбаатар хотноо олон улсын спортын наадмыг зохион байгуулж дэлхийд сурталчлан, таниулах ажлыг шат дараатай зохион байгуулсан байна.	2021 - 2025	Улс, нийслэл, бусад 11,200,0	Нийслэлийн төсөв 6,800.0	"Улаанбаатар 2023" Зүүн азийн залуучуудын наадмын бэлтгэл ажил 83.2 хувьд хүрсэн.	"Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадмын бүтээн байгуулалтын ажил 90 хувь (хөлбөмбөгийн ногоон талбай бүхий техникийн төв-100%, Спортын ордон /бэлтгэлийн төв/-80%)-тай үргэлжилж байгаа бол "Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг спорт, ёслолын ажиллагаа, наадмын байгууламжууд, байр, сууц, ажиллах хүч, хангамж, тээвэр, мэдээлэл технологи, хэвлэл мэдээлэл, олон улсын харилцаа, протокол, баталгаажилт, бүртгэл, аюулгүй байдал, олон нийттэй харилцах, маркетинг гэсэн 15 чиглэлд байгуулан гүйцэтгэл 76.3 хувьтай үргэлжилж байна. Үр дүн: "Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадам зохион байгуулах бэлтгэл ажлыг 83.2 хувьд хүргэсэн.	90 %	тодорхой үр дүнд хүрсэн	НБТСГ
ХЭРЭГЖИЛТ ДУНДАЖ ХУВЬ								81% буюу тодорхой үр дүнд хүрсэн	

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

Ж.ГАНБОЛД

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

М.ЦОГЗОЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНТУЯА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ЗАХИРГА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.БЯМБАСАЙХАН



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн
3/163 дугаар албан бичгийн 3 дугаар
хавсралт



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

2023 оны 06 дугаар сарын 13

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН БИЕЛЭЛТИЙГ ТАНИЛЦУУЛСАН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.

Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд биеийн тамир, спортын чиглэлээр туссан ажлын 2023 оны эхний хагас жилийн тайланд тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд биеийн тамир, спортын чиглэлээр туссан арга хэмжээний хүрээнд хийсэн ажлын тайлантай танилцаж, хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийг тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг, хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг шилжүүлэн тооцлоо.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.

Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд биеийн тамир, спортын чиглэлээр туссан 3.5 дахь зорилтыг хэрэгжүүлэхэд 5 арга хэмжээг хяналтад авч тэдгээрийн 2023 оны эхний хагас жилийн биелэлтийн явцыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолын дагуу явцын үнэлгээ хийж, тухайн зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн тул 2023 оны эхний хагас жилийн биелэлтийг 81 хувьтай буюу “тодорой үр дүнтэй” гэж үнэллээ.

№	Хэрэгжүүлж буй арга хэмжээ	Зарцуулсан төсөв (мян.төг)	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
---	----------------------------	----------------------------	------------------	-----------------	---------------	-------------------

3.5.1	Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна.	-	Биеийн тамирын арга зүйчийн тоо	Биеийн тамирын 9 арга зүйчтэй болсон байна.	0	30%
		-	Магадлан итгэмжлэгдсэн спорт клубын тоо	22	13	50%
		-	Иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт	58%	59%	100%
Эрчимжүүлэх шаардлагатай		Зорилтын дундаж хувь				60%
3.5.2	Дүүрэг, хороод болон шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир, спортын барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан байна.	-	Төрөлжсөн спортын талбай	105	139	100%
		-	Спортын барилга байгууламжийн хүртээмж Мкв	61	62	100%
Үр дүнтэй		Зорилтын дундаж хувь				100%
3.5.3	Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна.	Улсын төсвөөс 47.7 Нийслэлийн төсвөөс 357.1	Хамрагдсан иргэдийн тоо	800,000	335,345	70%
Тодорхой үр дүнд хүрсэн		Зорилтын дундаж хувь				70%
3.5.4	Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна.	Улсын төсвөөс 63.1 Нийслэлийн төсвөөс 173,8	Тэмцээнд оролцсон тамирчид	152200	122490	70%
		Орон нутгийн төсвөөс 27,4	Өсвөрийн шигшээ багуудын спортын төрөл	24	25	100%
Тодорхой үр дүнд хүрсэн		Зорилтын дундаж хувь				85%

3.5.5	Нийслэл Улаанбаатар хотноо олон улсын спортын наадмыг зохион байгуулж дэлхийд сурталчлан таниулах ажлыг шат дараатай зохион байгуулсан байна.	Нийслэлийн төсвөөс 6,800.00	Улаанбаатар хотноо зохион байгуулж буй Олон улсын спортын наадам зохион байгуулах	“Улаанбаатар - 2023” Зүүн азийн залуучуудын наадмыг зохион байгуулсан байна.	Бэлтгэл ажил 83.2%	90%
Тодорхой үр дүнд хүрсэн			Зорилтын дундаж хувь		90%	
Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.5. дахь зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2022 оны эхний хагас жилийн биелэлтийг 81 хувьтай буюу “тодорой үр дүнтэй” гэж үнэллээ.						

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ.

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.5 дахь зорилтыг хэрэгжүүлэхэд 5 хүрэх үр дүн, 9 шалгуур үзүүлэлтийг хангахаар тусгасан. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.5. дахь зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2023 оны эхний хагас жилийн биелэлтийг 81 хувьтай буюу “тодорой үр дүнтэй” гэж үнэллээ.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.ГАНБОЛД

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА М.ЦОГЗОЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН Б.ОЮУНТУЯА